



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 11/78

Мандалговь

“Хүлэмжийн цогцолбор” аж ахуйг хөгжүүлэх
бизнес төлөвлөгөөг боловсруулан
батлуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Гурван тулгуурт хөгжлийн бодлогын 3.1.1, 2021-2025 онд Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 8.3.2 дахь заалтууд болон аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвлийн нарлаг хүлэмжийг өргөжүүлэн “Хүлэмжийн цогцолбор” аж ахуйг хөгжүүлэх бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: М.Батсайхан (Аймгийн Тамгын газрын Үйлчилгээ албаны дарга)

Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

Н.Гэрэлмаа (Өмчийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

О.Амарбаясгалан (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Н.Цэнд-Аюуш (Жимс жимсгэний холбооны тэргүүн ахмад агрономич зөвлөх)

Б.Нармандах (Хувиараа хөдөлмөр эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн үйлдвэрлэл техник, технологи хариуцсан мэргэжилтэн)

2. Бизнес төлөвлөгөөг холбогдох тооцоо, судалгааны үндсэн дээр боловсруулан 2021 оны 05 дугаар сарын 10-ны дотор батлуулахыг ажлын хэсэг (Д.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И. ДОРЖБАТ



48621213